



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580

Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.04.22 № 435

танай _____ ны № _____ т

БУГАТ СУМЫН АРДЧИЛСАН
НАМЫН ХОРООНЫ ДАРГА
Х.УУГАНБАЯР ТАНАА

Нөхөн сонгуулийн мөрийн хөтөлбөр
хуульд заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит нөхөн сонгуульд оролцох Бугат сумын "Ардчилсан нам"-ын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит нөхөн сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн

632502867

баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт


Бугат сумын “Ардчилсан нам”-ын хорооны аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бугат сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр (. . . хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ



БУГАТ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН 2025-2028 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч, Улсын Их Хурлын болон аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал болон Улсын Их Хурлаас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулна.” гэсэн заалтыг үндэслэж, Бугат сумын Ардчилсан намын 2025-2028 оны мөрийн хөтөлбөрийг боловсрууллаа.

Энэхүү хөтөлбөрийг Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлан Үндэсний хөгжлийн газар, улс төрийн нам, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд, олон нийтийн саналд үндэслэн боловсруулж, 2025-2028 оны мөрийн хөтөлбөрөө тодорхойллоо.

Энэхүү мөрийн хөтөлбөр нь хүний хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлого, байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого, засаглалын бодлого, бүс, орон нутгийн хөгжлийн бодлого гэсэн бүлэг, зорилтоос бүрдэж байна.

НЭГ.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Аймаг, орон нутгийн онцлог, хүн амын амьдралын хэв маяг, хэрэгцээ шаардлага, эрүүл мэнд, боловсролын түвшинд нийцсэн бодлого, шийдвэрийг гарган хэрэгжүүлж, өрх, гэр бүлийн хөгжилд чиглэсэн хүн амыг эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэхийг зоринo.

1.1.Эрүүл мэнд

Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэн төлөвшүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

- 1.1.1. Эрүүл мэндийн төвийн дэд бүтцийг сайжруулж, оношилгоо, эмчилгээний дэвшилтэт технологийг нэвтрүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй үзүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.1.2. Эрүүл мэндийн төвийн яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмж, автомашинаар хангана.
- 1.1.3. Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлгийн үзлэгийг зохион байгуулж, эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.
- 1.1.4. Халдварт өвчний тандалт сэргийлэлтийг сайжруулж, эрт илрүүлэх идэвхтэй үзлэгийг зохион байгуулж, хариу арга хэмжээний бэлэн байдлыг дээшлүүлнэ.
- 1.1.5. Төрөлжсөн, сувилахуйн тусламж үйлчилгээг өргөжүүлэн, чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.1.6. Эрүүл мэндийн ажилтны чадавхыг сайжруулж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.
- 1.1.7. Эх, хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан өвчлөл, эндэгдлийг бууруулна.

1.2.Боловсрол

Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, төлөвшил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцах тогтолцоог бэхжүүлнэ.

- 1.2.1. Суралцагчийг бие даан, бүтээлчээр суралцахууд суралцах боломж олгох, тэдний авьяас, ур чадварыг хөгжүүлэх, хүмүүжил, төлөвшил, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, амьдрах ухаанд суралцуулах бодлого баримтлан ажиллана.
- 1.2.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургууль, цэцэрлэгийн хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргээн засах үйлчилгээг нийгэм, хамт олонд нь түшиглэн тогтмол үзүүлнэ.
- 1.2.3. Цахим сургалтын платформыг хөгжүүлж, цахим агуулга, цахим хичээл боловсруулж, бүх насны иргэдийн "Насан туршийн боловсрол"-ыг дэмжинэ.
- 1.2.4. Багшлах боловсон хүчний мэргэжил, арга зүйн хөгжлийг дэмжиж, тэднийг урамшуулах, харилцан туршлага солилцох боломжийг олгож, нийгмийн асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэхэд анхаарна.
- 1.2.5. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, боловсролын байгууллагуудад шаардлагатай хөрөнгө оруулалтыг үе шаттайгаар шийдвэрлэх замаар боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, "Хүүхдэд ээлтэй" сургалтын орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

1.3. Биеийн тамир, спорт

Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, амьдралын салшгүй хэсэг болгож, үндэсний болон өвөл, зуны спортуудыг дэмжиж, сумын баг, тамирчдын улс, тив, дэлхийн түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.

- 1.3.1. Хүн амыг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл дадал хэвшилд сургах, орчин нөхцөлийг сайжруулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааны үндсэн дээр хэрэгжүүлж, нийтийн биеийн тамирыг хөгжүүлнэ.
- 1.3.2. Үндэсний спорт болон уламжлалт тоглоом наадгай, олимпийн төрлийн спортуудыг бодлогоор дэмжиж, тамирчдын амжилтыг ахиулах, олон улс, улс, бүсийн чанартай уралдаан, тэмцээн зохион байгуулна.
- 1.3.3. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандартын шаардлага хангасан талбайн хүртээмжийг нэмэгдүүлж, материаллаг баазыг бэхжүүлнэ.

1.4. Соёл, урлаг

Соёлын төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үндэсний өв уламжлалыг залгамжилж, орчин үеийн соёл урлагийн чиг хандлагатай хослуулан хөгжүүлнэ.

- 1.4.1. Нутаг орны бахархал, Монгол өв соёлыг хойч үедээ өвлүүлэх, орчин үеийн соёл урлагийг түгээн дэлгэрүүлэх замаар соёл урлагийн тогтвортой хөгжлийг хангана.
- 1.4.2. Соёлын төвийн барилгыг засварлан, салбарын материаллаг баазыг сайжруулна.
- 1.4.3. Соёлын төвийн үйл ажиллагааг аялал жуулчлалтай холбон хөгжүүлж, урлаг, соёл, аялал жуулчлалын "Эвент" үйл ажиллагаанд оролцох.
- 1.4.4. Соёлын төв, иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд суурилан соёлын өвийг хамгаалалтад авах, соёлын биет болон биет бус өвийн оршин тогтнох чадавхыг бэхжүүлж, цахим соёлын санг бүрдүүлнэ.

1.4.5.Соёлын төвийн мэргэжилтэй боловсон хүчнийг орон нутгийн бодлогоор бэлтгэж, мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулж, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулахад анхаарч, нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого баримтална.

1.5.Хөдөлмөр эрхлэлт

Орон нутгийн бизнес эрхлэгчид, хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, шинээр бий болсон ажлын байрыг тогтвортой хадгалж, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

1.5.1.Сумынхаа хөдөлмөрийн зах зээлийн судалгааг үндэслэн орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр хэрэгжүүлж, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлнэ.

1.5.2.Өрхийн үйлдвэрлэл болон хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхол, боломжтой иргэдийг дэмжиж зээлэнд хамруулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, ажлын байранд зуучлах замаар шинэ ажлын байрууд бий болгоно.

1.6.Нийгмийн хамгаалал, халамж

Нийгмийн зорилтот бүлгийн иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээг гэр бүлд төвлөрүүлж, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настны болон хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах, жендэрийн тэгш байдлыг хангах, тэдний нийгмийн идэвх оролцоог дэмжсэн хөгжлийн төвүүдийг бий болгож, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлнэ.

1.6.1.Сумын хэмжээнд гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангана.

1.6.2.Хүн амын бүлгүүдийн хөгжил хамгааллыг сайжруулах зорилгоор хөгжлийн төвүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлж, тэдний ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.

1.6.3.Орон нутгийн түвшин дэх нийгмийн бүх харилцаанд жендэрийн тэгш байдлыг ханган ажиллана.

ХОЁР.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Эдийн засгийн бүтцийг сайжруулж, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ, үр ашгийг нэмэгдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулан эдийн засагт эзлэх хувь оролцоог дээшлүүлэхийг зорино.

2.1.Эдийн засгийн тогтвортой хөгжил

2.1.1.Эдийн засгийн хөгжлийн 2025-2028 оны үндсэн зорилтуудыг хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлнэ.


2.1.3.Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан сумандаа бий болсон үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжинэ.

2.1.4.Татварын тайлагналт, хураалтын үйл ажиллагааг цахимжуулж, ил тод байдлыг нэмэгдүүлэх замаар татварын үйлчилгээг иргэд, татвар төлөгчдөд хүндрэлгүй болгож, татварын бааз суурийг нэмэгдүүлнэ.

2.1.5.Төсөв, санхүүгийн цахим систем нэвтрүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, үр ашигтай болгож, төсвийн зардлын ил тод байдлыг хангана.

2.1.6.Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл хөтлөлт, олон улсын стандарт нэвтрэлтийг сайжруулах замаар төсвийн орлогын бүрдүүлэлт, төсвийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлж, удирдлагын бүх шатанд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн оновчтой шийдвэр гаргаж, хэрэгжүүлнэ.

2.2.Хөдөө аж ахуй



- 2.2.1. Хөдөө аж ахуйн салбарын материаллаг бааз, боловсон хүчний хангамжийг сайжруулна.
- 2.2.2. “Шинэ хөдөө-Булган” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг бүрэн хангаж, хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг сайжруулна.
- 2.2.3. “Чинээлэг малчин” дэд хөтөлбөрийг үргэлжлүүлж, малын чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, дотоодод мал, махны худалдааг нэмэгдүүлэн малчдын орлогыг өсгөнө.
- 2.2.4. Мал аж ахуй эрхлэлтийг дэмжих, өндөр ашиг шимтэй малын нийт сүрэгт эзлэх хувийг 25-д хүргэнэ.
- 2.2.5. Хадлан, бэлчээрийн талбайг зохистой ашиглах, нөхөн сэргээх, уст цэгийн хайгуул судалгаа хийж, бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлнэ.
- 2.2.6. Малын гоц халдварт, халдварт өвчний эрсдэл бүхий бүс нутагт мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг сайжруулна.
- 2.2.7. Мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнд антибиотек, пестицидийн үлдэгдэл тодорхойлж, малын эмийн зохистой хэрэглээг хангана.
- 2.2.8. Орон нутагт хэрэгжүүлж, хөрсний үржил шимийг хамгаалах, нөхөн сэргээх, үр сортын болон техник, технологийн шинэчлэлийг эрчимжүүлнэ.
- 2.2.9. Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийг механикжуулж, хүн амын хүнсний ногооны хэрэгцээг 50-аас доошгүй хувиар хангана.
- 2.2.10. Малын тэжээлийн ургамал тариалж, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх замаар мал аж ахуйн үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлнэ.

2.3. Үйлдвэрлэл, үйлчилгээ


- 2.3.1. Жижиг, дунд, үйлдвэрлэлийн зөвлөх үйлчилгээг хөгжүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэл хамтын ажиллагааг өргөжүүлнэ.
- 2.3.2. Жижиг, дунд үйлдвэрлэлд санхүүжилтийн олон эх үүсвэрээс дэмжлэг үзүүлнэ.
- 2.3.3. Үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулна.

ГУРАВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

3.1. Байгаль орчин

- 3.1.1. Ус, рашааны судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулж, усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, хэмнэх, хуримтлуулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 3.1.2. Сумын ойн сангийн ашиглалт, хамгаалалтын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.
- 3.1.3. Биологийн төрөл зүйлийг хамгаалах, өсгөн үржүүлэх санаачилгыг дэмжиж, хамтран хэрэгжүүлнэ.
- 3.1.4. Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг судалгаанд үндэслэн зохион байгуулж, сүлжээг өргөтгөнө.
- 3.1.5. Хог хаягдлын менежментийг боловсронгуй болгож, орчны бохирдол доройтлыг бууруулж, шинэ дэвшилтэт арга технологийг нэвтрүүлнэ.
- 3.1.6. “Жорлонгоо өөрчилъе” аяныг жил бүр зохион байгуулж, гэр хорооллын айл өрх, албан байгууллагыг байгальд ээлтэй боловсон 00-той болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

3.2. Аялал жуулчлал



- 3.2.1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, стандартыг сайжруулан баталгаажуулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.
- 3.2.2. Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжин, хамтран ажиллана.
- 3.2.3. Улсын болон орон нутгийн чанартай авто зам дагуу стандартад нийцсэн түр буудаллах цэг байгуулна.

3.3. Дэд бүтцийн төлөвлөлт, төв суурингийн хөгжил

- 3.3.1. Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хөгжлийн хэтийн зорилт, төлөвлөлттэй уялдуулан газар олголтын үйл ажиллагааг ил тод болгоно.
- 3.3.2. "Сайн хашаа", "Гудамж" төслүүдийн төлөвлөлтийг боловсруулж, бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 3.3.3. Сумын гэр хорооллын гудамж, талбайг бүрэн гэрэлтүүлэгтэй болгоно.
- 3.3.4. Орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг сайжруулна.

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулах замаар мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, цахим технологид суурилсан төрийн үйлчилгээг үе шаттай нэвтрүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлж, иргэдийн амар тайван амьдрах нөхцөлийг хангахыг зорино.

4.1. "Цахим Монгол" төрийн шуурхай үйлчилгээ

- 4.1.1. "Цахим Монгол" төрийн үйлчилгээг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ.
- 4.1.2. Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд олон нийтийн оролцоог хангана.

4.2. Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба-хүнд сурталгүй төрийн үйлчилгээ

Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.

- 4.2.1. Төр, иргэний нийгмийн байгууллагын түншлэлийг бэхжүүлж, шийдвэр гаргах түвшинд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, эрх ашгийг дээдэлсэн зөв бодлогыг хэрэгжүүлнэ.
- 4.2.2. Төрийн албаны хүний нөөцийг үе шаттай сургаж, мэргэшүүлэн төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.
- 4.2.3. Төрийн байгууллагад хандсан иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг цахимаар хүлээн авч шуурхай шийдвэрлэнэ.
- 4.2.4. Төрийн байгууллагуудын авлигыг таслан зогсоох, авлигаас урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээнүүдийг зохион байгуулж, төр иргэдийн энэ төрлийн мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.
- 4.2.5. "Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2016" олон улсын стандарт"-ыг төрийн байгууллагуудад нэвтрүүлнэ.

4.3. Хууль, эрх зүй, батлан хамгаалах

Иргэдийн аюулгүй амар тайван байдлыг хангана.


- 4.3.1. Сумын төвийн камержуулалтын нэгдсэн системийг шинэчлэн засварлаж, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг авч, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулж, нийтийн хэв журам, аюулгүй байдлыг хангана.
- 4.3.2. Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, зам тээврийн осол, түүнээс үүдэх хор уршгийг бууруулна.


- 4.3.3 Хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх, нөлөөллийн арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан өргөжүүлнэ.
- 4.3.4 Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна.
- 4.3.5 Иргэдэд эрх зүйн албан бус боловсрол олгох чиглэлээр хөтөлбөр батлуулан хэрэгжүүлнэ.
- 4.3.6 Сумын гамшгийн эрсдэлийн үнэлгээ, тойм судалгаа хийж, гамшиг аюулт үзэгдлийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч, техник тоног төхөөрөмжөөр үе шаттай хангана.
- 4.3.7. Батлан хамгаалах хууль тогтоомжийг хэрэгжүүлж, орон нутгийн хамгаалах тогтолцоог бэхжүүлнэ.

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Иргэдийн сумандаа сайхан амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийг зорино.

- 5.1. Орон нутгийн хөгжлийг дэмжиж, дэд бүтцийг хөгжүүлэн орон нутаг дахь иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлнэ.
 - 5.1.1. Өрхийн орлогод нийцсэн, амины, түрээсийн гэх мэт инженерийн шийдэл бүхий орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.
 - 5.1.2. Сумын инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
 - 5.1.3. Багийн төвүүдийг үүрэн телефоны сүлжээнд бүрэн хамруулж, нутаг дэвсгэрийн хэмжээгээр үүрэн холбоо, өндөр хурдны интернэт ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.
 - 5.1.4. Цахилгаан, эрчим хүчний хангамжийг сайжруулж, найдвартай ажиллагааг дээшлүүлнэ.
 - 5.1.5. Цөлжилтийн төлөв байдлын судалгаа хийж, тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.



НАМЫН ДАРГА  Х.УУГАНБАЯР

МОНГОЛ УЛСЫН
 ЦӨЛЖИЛТИЙН
 БУГАТ СУМЫН
 ХОРОО
 0100916 ХНТОВ